



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2012 оны 06 сарын 20 өдөр

Дугаар 163

Улаанбаатар хот

“Мандал генерал даатгал” ХХК-д зарим  
даатгалын хэлбэрээр үйл ажиллагаа эрхлэх  
зөвшөөрөл олгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3, 6.2.3, Даатгалын тухай хуулийн 13.1.2, Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 61 дүгээр тогтоолоор батлагдсан “Ердийн даатгал, давхар даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын 3.23 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Мандал генерал даатгал” ХХК-д даатгалын дараах хэлбэрээр ердийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгосугай.


1.1. Газар тариалангийн даатгал /1.6/;

1.2. Мал амьтдын даатгал /1.7/;

1.3. Санхүүгийн даатгал /1.11/.

2. Тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын биелэлтэд хяналт тавих, ердийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хавсралтад энэ тогтоолын 1 дэх хэсэгт заасан даатгалын хэлбэрүүдийг бүртгэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН